

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2020 ОНЫ 3 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.04.03

Сүхбаатар сум

**Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 хурлын тэмдэглэл, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн “Заавар батлах тухай” А/577 тоот тушаал, МХЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Заавар батлах тухай” А/192 тоот тушаал, МХЕГ-ын даргын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн А/28 тоот тушаалын дагуу Аймгийн Засаг даргын 2020 оны А/16, А/56, А/57, А/58, А/66, А/68, А/69 тоот захирамжуудыг гарган аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллаж байна.

Улсын онцгой комиссын гишүүн Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Онцгой байдлын ерөнхий газрын “Гал түймэртэй тэмцэх газар”-ын дарга, хурандаа Ц.Нямбаяр нараар ахлуулсан ажлын хэсэг тус аймагт ажиллаж, “Алтанбулаг боомт”-ын үйл ажиллагаатай танилцаж, үүрэг чиглэл, заавар зөвлөмж өгсөн.

Сум орон нутагт сумын төсвийн байгууллагууд хамтран гудамж талбай, үйлчилгээний байгууллагуудад эргүүлийн үүргийг тусгай хуваарийн дагуу гүйцэтгэж байна. Үүрэг гүйцэтгэх хугацаанд иргэдэд амны хаалт зүүх, хувийн ариун цэврийг сахих, бага наслын хүүхдийг гадуурч авч явахгүй байх сануулга зөвлөмж өгөн ажиллаж байна.

Аймгийн төвийн гудамж талбай, явган хүний зам, автозамын ариутгал халдвартгүйтгэлийн ажлыг гол түймэр унтраах автомшинаар хийлээ. Гол түймэр унтраах аврах 36-р ангийн нэг автомашиныг дайчлан 3 тонн усанд ариутгалын уусмал бэлтгэн Алтанбулаг хилийн боомтын зорчих хэсгийн талбайн ариутгал халдвартгүйтгэлийг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Онцгой комиссын шийдвэр, сумын Засаг даргын захирамжаар Алтанбулаг сумаас орох гарах хөдөлгөөнийг 3 дугаар сарын 26-28-ны өдрийг дуусталх хугацаанд хязгаарлах арга хэмжээ авч ажиллалаа.

Боомтоор нэвтэрсэн иргэдийн биеийн дулааныг хэмжин ариутгал халдвартгүйтгэл хийн Дархан-Уул, Орхон аймгуудад автомшинаар, Сүхбаатар-Баянбуурал чиглэлийн тусгай үүргийн хурдны галт тэргээр тус тус тээвэрлэн тусгаарлах арга хэмжээ авч, мөн боомтоор нэвтэрч буй ачаа тээврийн автомашинуудын жолооч болон техник хэрэгсэлд ариутгал халдвартгүйтгэл хийн цагдаагийн автомашины хяналт дор цуваанд оруулан гаалийн хяналтын талбайд хүргэх, ачааг буулгаж автомашиныг буцаах арга хэмжээг авч байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны 03-р сарын 31-ний байдлаар Алтанбулаг сумын Тамгын газрын байранд 10, Нийгмийн даатгалын тасгийн байранд 10, сумын сургуулийн дотуур байранд 25, Сүхбаатар сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн дотуур байранд 71, ахмадын сувилалд 27, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 19, нийт 162 иргэн тусгаарлалтад байна.


Шинэ коронавирусийн шинж тэмдэг илрээгүй, голомтод бус нутгаас Улаанбаатар хотын Бүянт-Ухаа боомтоор орж ирсэн иргэдийн жагсаалтаас Сэлэнгэ

аймгийн харьят иргэдийг тухай бүр шуурхай татан авч аймгийн Эрүүл мэндийн газарт хүргүүлэн тандалт хийлгүүлж байна. Тандалтанд нийт 42 иргэн хамрагдсан, иргэдийн биеийн байдал хэвийн, гарсан өөрчлөлтгүй байна.

Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг жигд тогтвортой хангах, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хүндрэлтэй байдал үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гол нэр төрлийн бүтээгдэхүүний нөөц, үнийн судалгааг сумдын болон аймгийн төвийн хүнсний зах, томоохон худалдааны төвүүдээс аваад байна. Мөн төмс, хүнсний ногооны нөөцийн судалгааг 7 хоног бүр гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2019 оны хяналт шинжилгээ үнэлгээний нэгдсэн тайланг, хавсралт тайлангуудын хамт боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүллээ.

Мандал, Сүхбаатар, Сайхан, Ерөө сумдад ажиллаж буй Төрийн үйлчилгээний цахим машин /ТҮЦ/-аас 2020 оны 1-р улиралд нийт 6136 удаагийн лавлагааг авч үйлчлүүлсэн байна. Үүний дийлэнх хувийг буюу 42 хувийг иргэний үнэмлэхийн лавлагаа, 18 хувийг Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа эзэлж байна.



### Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар

Галын аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Шадар сайдын баталсан Үйлдвэр агуулахын барилга байгууламжид гамшгаас хамгаалах дүрэм, стандарт, норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд 8 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулж илэрсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтэнд хяналт тавьж байна.

Тайлант сард аймгийн Онцгой байдлын газарт аюулт үзэгдэл ослын 9 удаагийн дуудлага ирсэн.

Үүнд: -Гэр орон сууцны гал түймрийн -6

-Аврах ажиллагааны – 2

-Ой хээрийн түймрийн – 1 дуудлага тус тус ирснийг бүртгэн, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Сүхбаатар сумын Бор-Гүвээ 5-р багийн 8 айл өрхөд бага насны хүүхдийг хараа хяналтгүйгээр орхихгүй байх, ахуйн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлж иргэдийн зөвшөөрлөөр гал түймэр гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа.

Гол нуурын мөсөнд цөмрөх, шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдэд санамж сээрэмжлүүлэг хүргэх зорилгоор эрэн хайх, аврах ангийн алба хаагчид мөс цөмрөх, шар усны үер буух эрсдэл бүхий газруудад урьдчилан сэргийлэх 4 ширхэг самбаруудыг байршуулж, энэ чиглэлээр зөвлөмж ярилцлагыг орон нутгийн хэвлэлийн байгууллагатай хамтран бэлтгэж, иргэдэд хүргэн түгээж ажиллалаа. Мөн ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шар усны үер, хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжийг sea.nema.gov.mn, Онцгой байдлын газрын page хуудас, аймгийн ЗДТГ-ын цахим хуудас, Сэлэнгэ зар зэрэг олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд түгээж байна.

## **Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар**

Шинэ коронавирусийн халдвартын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор A/12 тоот тушаал гарган байгууллагын шуурхай штаб байгуулж, тусгай горимын үед ажиллах төлөвлөгөө гарган, улсын байцаагч ажилтнуудын ажил үүргийг тодотгон, өндөржүүлсэн бэлэн байдлын үед зарлан мэдээлэх схемийг албан хаагчдад танилцуулж, баталгаажуулан улсын байцаагч, ажилтнууд 24 цагаар хариуцлагатай жижүүрийн үүргийг МХГ-ын штабын байранд гүйцэтгэж, замын постууд болон МХЕГ, ОБГ, ЭМГ, аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумдын шуурхай штабтай холбогдож, цаг үеийн мэдээллийг шуурхай солилцон ажиллаж байна.

Алтанбулаг, Сүхбаатар сумын ажиглалтын байранд байрлаж байгаа иргэдэд өгч буй хоол батлагдсан цэсийн дагуу хийгдэж байгаа эсэх, хоол үйлдвэрлэлийн газрын эрүүл ахуйн нэхцэл, ажиллагсдын хувийн ариун цэвэр, ундны усны чанар аюулгүй байдал, өдрийн хоолны илчлэгийг тодорхойлох зорилгоор аймгийн МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулж, тусгаарлалтад байгаа иргэдийн байрнаас гарч байгаа ахуйн болон аюултай хог хаягдалыг ариутгал халдвартгүйтгэлийн баг өдөр бүр тогтсон цагийн хооронд маршрутын дагуу тээвэрлэж хог хаягдлын нэгдсэн цэгийн тогтоосон газар шатааж, шороогоор дарж булшлах аргаар устгаж, халдвартгүйтгэл хийж байгаа байдал хяналт тавьж байна. Олон нийтийг хамруулан шашны зан үйл хийхгүй байх талаар 25 сүм, 11 хийдэд мэдэгдэл хүргүүлж, 5 сүмийн идэвхитэй цуглаанд оролцдог 114 гишүүний судалгааг авч, тандалт хийж байна. Мөн дугуйлан, секц, давтлага, өдөр өнжүүлэх төв, хүүхэд харах үйлчилгээ болон соёлын төвүүдэд олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахгүй байхад хяналт тавин ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 19 тоот албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах зорилгоор 37 эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, 3 эмнэлэгийн бэлэн байдлыг 80 хувьтай, 18 эмнэлэг 55 хувьтай, 16 эмийн санг 80 хувьтай хангуулан ажиллаж байна.

МХЕГ-ын даргын баталсан 01/13 тоот удирдамжийн дагуу хүнсний худалдааны 112, нийтийн хоолны 11, хүнсний үйлдвэр цех 11 хяналт шалгалтыг хийж, нийт 134 объектыг хамрууллаа.Хяналт шалгалтаар хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн 543 нэр төрлийн 1840 ширхэг, 19.5 литр, 11.1 кг буюу 6.398.000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг хураах акт үйлдэж хураан авч эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан эд зүйл хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах устгах орон тооны бус зөвлөлд шилжүүлж, үйлдвэрлэсэн он, сар, өдөр бичигдээгүй, хаяг шошгын зөрчилтэй 20 нэр төрлийн 17 кг, 124 ширхэг 1.111.500 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авалт хийлгүүлсэн.

Ил задгай худалдааг таслан зогсоох зорилгоор урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Цагдаагийн газартай хамтран малын мах, сүү, цагаан идээ ил задгай худалдаалж байсан 26 иргэний үйл ажиллагааг таслан зогсоосон.

Энэ сард зөрчлийн 5 хэрэг нээж хуулийн хугацаанд нь аймгийн прокурорын хяналтан дор бүрэн шийдвэрлэн ажиллалаа.

Тус газрын итгэмжлэгдсэн лаборатори нийт 38 аж ахуйн нэгжийн 122 дээжинд 492 үзүүлэлтээр шинжилгээ хийхэд 12 аж ахуйн нэгжийн 31 дээжийг 33 үзүүлэлтээр шилжилж, шинжилсэн дээжийн 25.1 хувь нь эерэг гарлаа.

## **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар**

Стандарт хэмжил зүйн газар 2015 онд Чанарын удирдлагын тогтолцооны олон улсын ISO 9001 стандартыг үйл ажиллагаандаа амжилттай нэвтрүүлж Францын баталгаажуулалтын байгууллага /AFNOR/-аас гэрчилгээг хүлээн авснаас хойш 2015, 2016, 2017, 2018 онуудад давтан үнэлгээнд хамрагдаж ирсэн бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд ээлжит үнэлгээг онлайнаар явуулсан бөгөөд орон нутгийн хэлтсүүдийг төлөөлөн Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтсүүд хамрагдсан.

Боловсрол, соёл, урлагийн газраас аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нарт зохион байгуулсан цахим хуралд хэлтсийн дарга оролцож, шинээр батлагдсан “ЕБС-ийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 6782:2019”, “ЕБС-ийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6781:2019” стандартын талаар мэдээлэл өглөө.

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Сүхбаатар, Баянгол, Сант, Шаамар сумын 14 аж ахуйн нэгжийн 1 супермаркет, 2 минимаркет, 7 хүнсний дэлгүүр, 1 худалдааны агуулах, 1 хүнсний муҳлаг 1 зоогийн газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж стандартын шаардлага хангасан 13 иргэн аж ахуйн нэгжид аймгийн орон тооны бус баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр тохирлын гэрчилгээ олгосон.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Сүхбаатар сумын 5-р багт байрлалтай “Сэ Тэ Би” ХХК-ий “Сэлэнгэ” нэрийн зөгийн бал, Ерөө сумын “Моностойн нуруу” ХХК-ий “Ноёт” арвайн гурилыг МХГ-ын итгэмжлэгдсэн лабораторит сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан.

Мөн Сүхбаатар сумын “Эмээгийн талх” цехийн 6 нэрийн бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэн шинээр хийлгэж, технологийн заавар, дотоод журам боловсруулах талаар аргазүйн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Стандартын салбар сан:

Тус сангаас 11 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 5 нэрийн 17 стандартаар хангаж, арга зүйн зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Хэмжил зүйн лаборатори нь 6 аж ахуй нэгж байгууллагатай “Хэмжих хэрэгсэл баталгаажуулах, шалгалт тохируулга хийх гэрээ” байгууллаа.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр 2 аж ахуйн нэгжийн 4 жин, 1 хэмжээт саванд шалгалт тохируулга хийж, механик хэмжлийн төрлөөр Сүхбаатар, Алтанбулаг сумын худалдаа үйлчилгээний байгууллагуудад ашиглаж байгаа 45 жин, Мандал сумын нэгдсэн эмнэлгийн лабораторийн 1 электрон жинг шалган баталгаажуулалт хийсэн. Цахилгааны хэмжлийн төрлөөр айл өрх, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 1 фазын 23 ширхэг тоолуурыг шалган баталгаажуулсан. Мөн эмнэлэг, иргэн, аж ахуйн нэгжийн 7 ш термометр, 15 ширхэг цусны даралтын аппарат, автоклавын манометрийг шалган баталгаажуулж ажиллалаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2019 оны нэгтгэсэн тайланг Сэлэнгэ аймаг дахь аудитын газарт аudit хийлгэхээр хүргүүлэх ажлыг зохион байгуулж, ажиллалаа. 4-р сарын 1-ний байдлаар 210 төсөвт байгууллага, 16 ОНӨҮААТҮГазар, 17 сум хөгжүүлэх сан, 17 сумдын төрийн сангийн тайланг хүргүүлээд байна.

**1. Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

/2-р сарын гүйцэтгэлээр /

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
	<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>	<b>22,571,397.2</b>	<b>19,778,913.2</b>	<b>87.6</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>5,072,183.8</b>	<b>4,972,927.0</b>	<b>98.0</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,415,063.4	4,030,924.2	91.3

	Сумдын төсвийн орлого	657,120.4	942,002.9	143.4
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,301,827.3	1,301,827.3	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	9,746,303.1	9,746,303.1	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	791,848.5	213,881.0	27.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	3,242,260.1	3,242,260.1	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	301,714.7	301,714.7	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	2,115,259.7		
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>22,571,397.2</b>	<b>15,201,308.5</b>	<b>67.3</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>22,571,397.2</b>	<b>15,201,308.5</b>	<b>67.3</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	3,836,352.4	2,295,963.8	59.8
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	47,114.0	47,114.0	-
	Сумдын сум хөгжүүлэх сан	-	-	-
	<b>Аймгийн шууд харьцагдаг байгууллагуудын зарлага</b>	<b>7,089,663.8</b>	<b>4,065,828.7</b>	<b>57.3</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,005,088.8	189,857.6	18.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	791,848.5	212,000.0	26.8
	Халамжийн сан	16,800.0	14,400.0	85.7
	Шууд харьцагдаг төсвийн байгууллагуудын зарлага	<b>5,123,575.1</b>	<b>3,555,555.0</b>	<b>69.4</b>
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	152,351.4	94,016.1	61.7
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	11,350,354.6	8,588,928.9	75.7
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	247,912.4	203,473.1	82.1
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		<b>15,288,546.9</b>	<b>4,968,065.6</b>	<b>89.6</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,703,281.3	3,696,038.5	78.6
3.2	<b>Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>47,114.0</b>	<b>47,114.0</b>	<b>100.0</b>
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	47,114.0	47,114.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	
3.3	<b>Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>791,848.5</b>	<b>213,881.0</b>	<b>27.0</b>
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	791,848.5	213,881.0	27.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	-	-	
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	9,518,686.9	9,518,686.9	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	227,616.2	227,616.2	100.0
3.6	<b>Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/</b>	<b>9,746,303.1</b>	<b>9,746,303.1</b>	<b>100.0</b>
	- Ерөнхий боловсролын сургууль	5,120,073.2	5,120,073.2	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	3,045,146.3	3,045,146.3	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	1,327,632.9	1327,632.9	100.0
	- Газрын кадастрын байгууллага	132,671.7	132,671.7	100.0
	- Хүүхдийн байгууллага	120,779.0	120,779.0	100.0
<b>4. Тусгай сангийн зарлага</b>		<b>530,346.7</b>	<b>178,197.6</b>	<b>33.6</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	530,346.7	178,197.6	33.6

**2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:**

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл	2019 02- сар	2020 02- сар	2020- 02 2019-02 Х/төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>			
<b>1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
Талх /орон нутгийн, ш/	1 200	1 200	100.0
Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
Будаа /кг/	2 400	2 400	100.0
Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
<b>2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
Хонины мах /кг/	6 500	8 000	123.1
Үхрийн мах /кг/	8 300	9 500	114.5
Адууны мах /кг/	7000	7 500	107.1
Ямааны мах /кг/	6 000	7 500	125.0
Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
Хиам /чанасан, кг/	10 000	10 000	100.0
<b>3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
Сүү /задгай, л/	1 800	1 800	100.0
Сүү / савласан, л/	2 600	3000	115.4
Тараг /задгай, л/	2 000	2 000	100.0
Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
Айраг /л/	3 500	4 000	114.3
Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
Өндөг /ш/	350	350	100.0
<b>4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
Ургамлын тос /л/	3 800	4 000	105.3
Өөхөн тос /кг/	2 000	2 000	100.0
Шар тос /кг/	13 000	15 000	115.4
Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5 ХҮНСНИЙ НОГОО</b>			
Төмс /кг/	1 000	1 000	100.0
Лууван /кг/	1200	1 200	100.0
Манжин /кг/	1200	1500	125.0
Байцаа /кг/	1500	1200	80.0
Сонгино /кг/	1500	1800	120.0
Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 200	120.0
Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 300	3 000	130.4
<b>7 ШАТАХУУН</b>			
Бензин А - 80	1 645	1 750	106.4
Бензин А - 92	1 725	1 840	106.7
Дизелийн түлш	2 275	2 470	108.6

**Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 2 сард 45 холбогдгчтой 275.6 сая төгрөгийн хохиролтой, 146 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үетэй адил түвшинд байна. Гэмт хэргийн илрүүлэлт 19.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 0,3 хувиар өссөн байна. 4837 зөрчил илрүүлсэн нь 271 зөрчлөөр буюу 5.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 3 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 191, газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ 88, лавлагаа 11 олгосон.

- Иргэний бүртгэлийн чиглэлээр дараах үйлчилгээг үзүүлж ажиллалаа. Үүнд:
- ✓ Төрсний бүртгэл – 220 /эрэгтэй-98, эмэгтэй-122/
  - ✓ Гэрлэлтийн бүртгэл – 29
  - ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 12
  - ✓ Үрчлэлт - 2
  - ✓ Эцэг тогтоолт – 5
  - ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 15
  - ✓ Нас баралт – 50
  - ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 395
  - ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 118
  - ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 96
  - ✓ Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан – 181
  - ✓ Гадаад паспорт олголт – 49
  - ✓ ОХУ-ын хавсралт -722 тус тус бүртгэгдсэн байна.

Төрийн архиваас тайлант сард доорхи ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

-Байгууллагын архивт хадгалах хугацаа дууссан 2011 оныг хүртэлх хугацааны байнга хадгалагдах баримтыг төрийн архивт шилжүүлэх тухай албан бичгийг боловсруулан аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын ЗДТГ, Түнхэл тосгоны Захирагчийн албанд тус тус хүргүүлсэн.

-Монгол Улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын дарга, Хууль зүйн сайдын 1992 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 10/124 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан журмын дагуу Хөтөлийн Цемент шохойн хувьцаат компанийн архивт хадгалагдаж байгаа 1983 оноос хувьчлагдах хүртэлх хугацааны байнга хадгалагдах баримтын бүртгэлийг ирүүлэх тухай албан бичгийг компанийн захиргаанд хүргүүлсэн.

-Аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн албан бичгийн дагуу тус архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа зураг төсөл, газрын салбарын холбогдолтой баримтын судалгааг гаргаж хүргүүлсэн.

-Сэлэнгэ аймгийн харьят эрдэмтдээс бүрдсэн Эрдэмтдийн зөвлөл байгуулах ажлын хүрээнд зөвлөл байгуулах тухай захирамжийн төслийг боловсруулсан бөгөөд их сургуулиудад хүргүүлсэн албан бичгийн дагуу ирүүлсэн эрдэмтдийн судалгааг нэгтгэх ажлыг хийж байна.

-Жавхлант сумын ЗДТГ-ын хөмрөгийн 1976-2010 оны 126 хадгаламжийн нэгж бүхий бүртгэлийг шинэчлэн боловсруулж, түүхчилсэн лавлах бичих ажлыг хийж байгаа бөгөөд цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай 1977-2010 оны 35 ХН-ийн судалгааг гаргасан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сант суман дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Жавхлант сумын ЗДТГ-ын хөмрөгийн 36 хадгаламжийн нэгжийн 4046 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 3025, хүний нэр 15672, газар зүйн нэр 1733, байгууллагын нэр 2293 шивж эх баримтай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.

Завхан аймгийн Улиастай сумын иргэн Б.Алтанбаганын ирүүлсэн өргөдлийн дагуу улсад ажилласан жилийн лавлагааг гаргаж хүргүүлсэн.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар 389, цаасан суурьтай баримтаас 36, мастер хувиас 50, архивын тодорхойлолт 475, магадлагаа 44 тус тус гаргаж үйлчилсэн бөгөөд архивын лавлагааны орлогоос 978800 төгрөг оруулсан байна.

### **Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр**

Хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон, хөл хороо тогтоосон хугацаанд 2020 оны 03 дугаар сарын 11-18-ний хооронд Сүхбаатар сумын ерөнхий

боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн удирдлагууд зах худалдааны төв, тоглоомын газрууд, дэлгүүр, хоолны газраар эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 85 сурагчид халдвараас урьдчилан сэргийлэх маск зүүж явах, онцын шаардлагагүй бол гэрээс гаражгүй байх, гараа угаах, гараа ариутгах зөвлөгөөг өгч, эцэг эхэд нь олон нийтийн газраар хүүхдээ дагуулж явахгүй байх, Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын шийдвэрүүдийг дагаж мөрдөхийг зөвлөлөө.

Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор салбарын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, шуурхай удирдлагаар хангах мэдээ, мэдээлэл солилцох үүрэг бүхий БСУГ-ын “Шуурхай штаб”-ыг байгуулан, жижүүрийн хуваарийг гарган ажиллаж байна.

Байгууллагаар үйлчлүүлж байгаа иргэдэд ариутгал халдвартгүйжилтийн талаар зөвлөгөө өгч, амны хаалт зүүж үйлчлүүлэх, сургууль, цэцэрлэг, соёл урлагийн байгуулагуудын ажил үйлчилгээтэй холбоотой болон байгууллагын нөхцөл байдлын талаарх мэдээллийг аймгийн шуурхай штабын 70363684 дугаарт мэдэгдэж цахим хаягаар тайланг явуулж байна. 2020 оны 03 дугаар сарын 20-ны байдлаар 134 иргэн үйлчлүүлсэн байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг чанартай хүргэх, бага насны хүүхдэд тавих анхаарал, хараа хяналтыг сайжруулах, болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй, ухаалаг зөв хэрэглээ, амьдралын зөв дадал хэвшлийг гэр бүлийн орчинд хэвшүүлэх зорилгоор “Хүүхэд эрхэм хэрэглэгч 2020” арга хэмжээг зохион байгуулдаг бөгөөд энэ хүрээнд Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран “Миний гэр-Аюулгүй орчин” захидлын уралдааныг цахимаар зохион байгуулж ажиллалаа. Үүнд: Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас 2020 оны 03 дугаар сарын 11-ний 4/1396 албан тоотоор ирүүлсэн удирдамжийг 2020 оны 03 дугаар сарын 13-ны 15.10 цагт [selenge@mecs.gov.mn](mailto:selenge@mecs.gov.mn) хаягаар ерөнхий боловсролын 35 сургуульд хүргүүлсэн.

“Хүүхэд эрхэм хэрэглэгч” цахим хуудсанд байршуулсан мэдээлэл, танилцуулга, сурталчилгааны материалын болон “Миний гэр аюулгүй орчин” захидлын уралдааны удирдамжийг байршуулсан ба “Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар” цахим хуудсанд 03 дугаар сарын 12-ноос хойш хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжүүлэх зэрэг аргын талаар 21 удаагийн мэдээлэл оруулсныг давхардсан тоогоор 25766 иргэн уг мэдээллийг үзэж, 534 хүн уг мэдээлүүдийг хуваалцсан байна. 2020 оны 03 дугаар сарын 20-ны байдлаар “Миний гэр аюулгүй орчин” захидлын уралдаанд бага ангийн 684, дунд ангийн 642, ахлах ангийн 354 сургач, нийтдээ 1680 сургач Харилцаа холбооны зохицуулах хорооны [ekids@crc.gov.mn](mailto:ekids@crc.gov.mn) хаягаар захидлаа хүргүүлсэн байна.

2020 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрээр зайн сургалтаар зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоол болон БСШУС-ын сайдын тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар БМДИ-ээс аймаг, дүүргийн БСУГ-т мэдээлэл өгөх, санал солилцох зорилгоор 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдөр видео хурал зохион байгуулахад оролцож, нөхцөл байдлын мэдээллийг өгч ажиллалаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын дагуу эхний жилдээ ажиллаж байгаа багшийн үндэсний үндсэн сургалтад хамрагдахаар манай аймгаас бүртгүүлсэн 174 хүнээс онлайн даалгавраа хийгээгүй 69 багшийг судлагдахуун бүрээр гарган холбоо барьж, шалтгааныг тодруулан үндэсний үндсэн сургалтандаа идэвхтэй хандахыг санууллаа. Мөн “Багшилх эрхийн үнэмлэх” нь сунгагдсан 5 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн үндсэн сургалтад хамрагдсан 32, 10 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн сургалтад хамрагдсан 24 багшийн мэдээллийг хүлээн авч, нэгж байгууллага, багш нарт хүргэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын даргын 2019 оны А/09 тоот тушаалаар батлагдсан “Соёлын төв-Чанартай үйлчилгээ-IV”

удирдамжийн дагуу уралдааныг аймгийн Засаг даргын 2019 оны А/423 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн шалгаруулалтыг зохион байгууллаа.

Тус уралдаанд 14 сум 5 тосгоны нийт 19 соёлын төв 2019 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг илтгэх материалуудыг ирүүлснийг 2020 оны 02 дугаар сарын 15-аас 03 дугаар сарын 06-ны өдөр хүртэл ажлын хэсэг хяналтын хуудсын дагуу шалгаруулж, нийлбэр дүнгээр Ерөө сумын соёлын төв, Жавхлант сумын соёлын төв, Баянгол сумын соёлын төвүүд эхний 3 байрыг эзэлж, улсын уралдаанд оролцуулахаар материалыг хүргүүлсэн.

## **2. Эрүүл мэндийн талаар:**

Сүрьеэг устгах өдрийг “ЦАГ НЬ БОЛЛОО” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна. ЭМЯ, НЭМҮТ-өөс ирүүлсэн 12 төрлийн цахим постер, 6 төрлийн шторкыг 7 хоногийн хугацаагаар олон нийтийн цахим сүлжээнд цацаж, 3 дугаар сарын 25-ны байдлаар видеог 1052 иргэн, постерыг 1289 хүн үзсэн байна. Сүрьеэгүй Сэлэнгэ гар зургийн уралдааныг 2 сум, тосгонд зарлаж дүгнэсэн.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшил, сургууль цэцэрлэгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад нийт 1361 ажилчдыг шинэкоронавирусийн (COVID-2019)-ийн үед ажиллах заавар, Эрүүл мэндийн сайдын 135, 537 тоот тушаалууд, ДЭМБ-ын түр удирдамж болон холбогдох тушаал заавар, зааварчилгаа, эмнэлзүйн удирдамжийг хүргүүлэн ажлын байрны сургалтуудыг тухай бүр хийж байна.

Бүх шатны эрүүл мэндийн төвүүдэд 1-2 тусгаарлах өрөө, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасгийн бэлэн байдлыг тоног, төхөөрөмж, нэг удаагийн хувцас хэрэгсэл, халдвартгүйтгэлийн бодисын нөөц, эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдлыг хангулсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/68 захирамжийн дагуу Сайхан, Баянгол, Сүхбаатар сум Дулаанхаан тосгоны авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, хяналтын цэгүүдэд 2-р сарын 23-наас 3-р сарын 02-ныг хүртэлх өдрүүдэд нийт 132 эмнэлгийн мэргэжилтнийг дайчлан ажиллуулж байна.

Баянгол, Сайхан, Шаамар, Сүхбаатар, Алтанбулаг сум Дулаанхаан тосгоны хяналтын цэгүүдэд нийт 2599 тээврийн хэрэгслийн 6678 зорчигдын биетийн халууныг хэмжсэнээс халуун ихэссэн хүн бүртгэгдээгүй, сурталчилгааны материалыг давхардсан тоогоор 4014 зорчигчдод тарааж зөвлөмж өгөөд байна. Коронавируст халдвараас сэргийлэх сургалт сурталчилгааг 516 аж ахуй нэгж байгууллагад, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 111 удаагийн мэдээлэл, зөвлөмжийг өгч, цахим орчинд сургалт сурталчилгааны 1038 мэдээллийг тавин, 12844 сурталчилгааны материалыг тарааж ажиллалаа. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудад тусгаарлах орны тоо 63 байна.

## **3. Хөдөлмөр, нийгмийн хalamжийн үйлчилгээний талаар**

2020 оны 3-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 611 байсан бол 95 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 46 ажлын байранд 40 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 121 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 545 болсон байна.

Тайлант хугацаанд хalamжийн санд улсын төсвөөс 4,923,295.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 34800,0 мянган төгрөг, нийт 4,958,095.1 мянган төгрөгийн төсөв батлагдсан.

### **Орон нутгийн төсвийн орлогоос:**

2020 оны 3 сарын байдлаар Онцгой тохиолдлын тэтгэмжид 8 иргэнд 9600,0 мянган төгрөгийг олгосон.

### **Улсын төсвийн орлогоос:**

Хalamжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 29656 иргэнд 4,934,395,7 мянган төгрөгийг олгоод байна.

Үүнд:

- Нийгмийнхаламжийнтэтгэвэрт 2386 иргэнд 1242349.1 мянган төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1703 иргэнд 39153.3 мянган төгрөг
- Амьжирааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 390 иргэнд 204824.7 мянган төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 826 эхэд 65426.8 мянган төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4137 эхэд 432692,3 мянган төгрөг
- Өрх толгойлсон эх/эцэгийн тэтгэмж 174 иргэнд 790943,0 мянган төгрөг
- Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусlamжинд 1917 ахмадын 91756.9 мянган төгрөг
- Алдар цолтон ахмад настанд 59 ахмадад 25790.0 мянган төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусlamжинд 202 иргэний 18594.2 мянган төгрөг
- Алдарт эхийн одон 8649 эхэд 1125400,0 мянган төгрөг
- Насны хишиг үйлчилгээг 4754 ахмадад 372090,0 мянган төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмж 5 хүүхдэд 10000,0 мянган төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 4908 иргэнд 111227,1 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

#### **4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар**

Хүүхдийн тусlamжийн 108 утасны үйлчилгээний төвөөс шилжин ирсэн 10 дуудлагыг хяналтандaa авч, хамтарсан баг хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлсэн.Дуудлагыг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрээр нь ангилбал:

- Сэтгэл санааны хүчирхийлэл – 7
- Үл хайхрах хүчирхийлэл – 3

Хүчирхийлэл үйлдэгдсэн орчноор нь ангилбал:

- Гэр бүлийн орчинд – 10

Эрсдэлийн төвшингөөр ангилбал:

- Дунд эрсдэлтэй – 4
- Бага эрсдэлтэй -6

Амьжирааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 414 өрхийн 1303 хүүхдэд түргэвчилсэн үнэлгээг хийж хэрэгцээг тодорхойлон, хүүхэд хамгааллын зураглалыг гаргахад улаан бүсэд 376 хүүхэд, шар бүсэд 130 хүүхэд, ногоон бүсэд 853 хүүхэд хамрагдсан байна. Үүнээс улаан бүсэд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг 166 хүүхдэд гар ариутгагч, амны хаалт, витаминжуулалт тарааж, дэмжлэг үзүүлсэн.

Бие махбодын хүчирхийлэлд өртсөн Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн харьят 6 настай А-г аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэвтүүлж эм тария, ахуйн хэрэглээ, хувцас хэрэгслийн дэмжлэг үзүүлэн аав “О”, ээж “У” нарт хүлээлгэн өгч, тохиолдлыг Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэст шилжүүлсэн.

Сүхбаатар сумын 4 дүгээр багийн иргэн “Н” цагдаагийн байгууллагад шалгагдан хоригдож байгаа учир 5 настай охин “Н”-ийг Алтанбулаг сум дахь Түр хамгаалах байранд тусгаарлан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн.

Цагааннуур сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт хэсэг уяачид хурдан морины уралдаан зохион байгуулах гэж байсныг мэдээллийн дагуу сум орон нутгийн удирдлагуудтай хамтран таслан зогсоох арга хэмжээг авсан.

Хөл хорио тогтоосонтой холбогдуулан Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн дунд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр “Эх дэлхийдээ Эрүүл оршихуй” 2050 онд илгээх цахим захидалын уралдааныг зохион байгуулсан.

Нийт сум, тосгодын төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад 5 төрлийн уриалга, 3 зөвлөмж, 3 шторкыг хүргүүлж Сэлэнгэ хүүхэд, Сэлэнгэ гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар пэйж хуудсанд байршуулсан.

Залуучууд коронавирусийн эсрэг нэгдэж байна аяны хүрээнд Цагдаагийн байгууллагатай хамтран “Залуучууд коронавирусийн эсрэг нэгдэж байна” плакат, амны хаалт зүүх, гараа тогтмол угааж хэвших санамж зөвлөгөөг хэвлэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, хөл хөдөлгөөн ихтэй газар, айл өрхийн орцны үүдэнд байршуулсан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал хуваарийн дагуу хуралдаж байнгын асаргаа сунгахаар 19 хүүхэд орсноос асаргаа 10, хөгжлийн бэрхшээлтэйг тодорхойлсон 1, онош тодруулахаар 8 хүүхдийг буцаасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүчирхийллийн хохирогч 1 хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг хүргэж ажиллалаа.

Засгийн газрын 2019 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 57 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2017 оны А\127 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд хурдан морины үсэргээ, сунгаа, уралдаан зохион байгуулахгүй байх талаар сумдын Засаг дарга нарт албан даалгаврыг хүргүүлсэн.

##### **5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:**

2020 оны 03 дугаар сарын байдлаар 6,6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтэйгээс 03 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 6,0 тэр бум төгрөгийн орлого төвлөрүүлж 91,6 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17188 тэтгэвэр авагчдад 12,868,092 мянган төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 1193 хүнд 563,262 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 203 хүнд 191,359 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 84 хүнд 222,142 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг 2020 оны 03 дугаар сард 2 удаа хийж, 422 иргэнийг материалыг хэлэлцэнээс 45 иргэний актыг цуцалж, 16 иргэн шинээр тогтоолгож, 361 иргэний актыг сунгасан.

Нийгмийн даатгалын архивын лавлагааг 2020 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар 415 иргэн, даатгуулагчдад гаргаж, түргэн шуурхай үйлчилсэн.

##### **Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний чиглэлээр:**

“Атар -4” аяны хэрэгжилтийг эрчимжүүлэх, хаврын тариалалтын бэлтгэлийг хангаж, технологийн горимыг хангуулах зорилгоор зохион байгуулсан ажил, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг 7 хоног бүр сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн яаманд мэдээлж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны хаврын тариалалтанд зориулж 356 аж ахуй нэгж, иргэд 22 мян,тн үрийн захиалга өгснөөс 123 аж ахуй нэгж 12 мян,тн үрийн буудай нөөцөлж, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулсан.

Улаанбуудайн үйлдвэрлэл эрхлэгчдийн хаврын тариалалтанд шаардагдах улаанбуудайн үрийн захиалгыг сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

2020 онд 144 мянган га талбайд улаанбуудай, 1200 га талбайд арвай, 3000 га талбайд овьёос, 3287 га талбайд бусад үр тариа, 12 мянган га-д тэжээлийн ургамал, 21 мянган га-д тосны ургамал, нийт 191 мянган га талбайд тариалалт хийх төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 4856 малчин, 4670 мал бүхий өрх, 63 аж ахуй нэгж байгууллагад 1682489 толгой мал өвөлжиж хаваржиж байна. 2019-2020 оны өвөл хаврын бэлтгэлийг малчдын түвшинд 100 хувь хангасны хүчинд өвс тэжээлийн

хомсдол үүсч өвөлжилт хүндээрсэнгүй. Цаг агаар урьд өмнөх жилүүдээс харьцангуй дулаан өвөл болсон нь мал сүрэг өвлүүг өнтэй сайхан давж урин цагтай золголоо.

Говийн болон баруун аймгуудад зуншлага тааруу газрын гарц муутай байсан зэргээс шалтгаалан Өвөрхангай, Төв аймаг, Завхан, Дундговь аймгаас отор нүүдэл Орхонтуул, Сайхан сумдын нутгийг урд хэсгээр орж ирж байна. /Орхонтуул суманд өвөрхангай аймгаас 15 өрхийн 11000 толгой мал, Сайхан суманд Өвөрхангай, Завхан аймгаас 2 өрх 570 толгой мал, Орхон суманд 2 өрхийн 2000 толгой мал отроор хаваржиж байна.

Мал төллөлт төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг сумдаас гаргуулан авч нэгтгэн холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллаж байна. аймгийн хэмжээнд 788735 толгой хээлтэгч мал төллөхөөс 82417 толгой мал төллөөд байна. Үүнээс гүү-238, Үхэр-3129, эм хонь 43550, эм ямаа-35563 төллөж мал төллөлт 10,4 хувьтай, төл бойжилт 99,8 хувьтай байна. Төлийн хорогдол 125, том малын зүй бус хорогдол 611 байна.

Аймгийн хэмжээнд мал эмнэлгийн нэгдсэн системийг 2020 оны 01 сарын 01-ээс нэвтрүүлж 17 sumaас 1812 иргэнд цахим гэрчилгээгээр адуу 457, үхэр 1375, тэмээ 0, хонь 4938, ямаа 2556, гахай, тахиа 3, бусад 1 бүгд 9330 толгой мал амьтан, адууны мах 45635, үхрийн мах 228129, тэмээний мах 50, хонины мах 95800, ямааны мах 57172, гахайн мах 1441, дайвар мах 3964 кг бүгд 423191,3 кг, адууны шир 307, үхрийн шир 1905, хонины нэхий 3732, ямааны арьс 4273, сүү 1351,4, ааруул 151, өрөм 61 кг тус тус нөхөр үүслийн цахим гэрчилгээ олгож баталгаажууллаа.

Мал амьтны шилжилт хөдөлгөөнөөр адуу 1245, үхэр 1354, тэмээ 3, хонь 6706, ямаа 5942, нийт 15250 толгой мал шилжин ирсэнээс отроор адуу 1215, үхэр 1303, хонь 6686, ямаа 5917, тэмээ 3 бүгд 15124 толгой мал, арилжаагаар адуу 30, үхэр 51, хонь 20, ямаа 25 бүгд 126 толгой мал тус тус шилжин ирсэн. Өөр аймаг сумруу адуу 85, үхэр 85, хонь 239, ямаа 172, гахай 6 бүгд 587 толгой мал шилжин явсанаас. Отроор адуу 3, хонь 162, ямаа 105 бүгд 270 толгой мал, арилжаагаар адуу 76, үхэр 85, хонь 77, ямаа 67, гахай 6, бүгд 301 уралдаанд адуу 6 толгой мал шилжин явсан дүнтэй байна.

Алтанбулаг боомтоор ОХУ-аас импортоор оруулсан 24 толгой адууг “Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, “Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай” хуулийн тус тус үндэслэн Сүхбаатар сумын Засаг даргын захирамжаар тус сумын 8 дугаар багийн нутагт хорио цээрийн дэглэмд оруулан аймгийн Мал эмнэлгийн газрын магадлан итгэмжлэгдсэн лабораторит адууны халдварт цус багадах, ям, адууны нийлүүлгийн өвчний шинжилгээнд 24 толгой адууг хамруулахад сөрөг дүнтэй гарсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын мал эмнэлгийн үйл ажиллагаанд хяналт тавих 01 тоот нэгдсэн удирдамж, мал эмнэлгийн газрын даргын 01,02 тоот хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 128 хуулийн этгээд, 1 иргэнд хяналт шалгалт явуулж 18 зөрчил илрүүлэн 8 зөрчлийг арилгуулан 17 сумын мал эмнэлгийн 10 улсын байцаагчийн 4 дүгнэлт гаргаж 67 хуулийн этгээдэд 192 заалтай 269 иргэнд 322 заалттай зөвлөмж хүргэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн үйл ажиллагааны бэлэн байдлыг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж буй хүнсний зах, худалдааны төв, нийтийн хоолны газрын хүнсэнд хэрэглэгдэж байгаа мал, амьтны гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир, ноос ноолуур, өндөг, цагаан идээ, дайвар бүтээгдэхүүнд мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээг олгож байна. Тайлант сард адууны 590 кг махны 5 дээж, 4520 кг үхрийн махны 31 дээж, 728 кг хонины махны 16, 50 кг дайвар бүтээгдэхүүний 1, 510 л сүү, сүүн бүтээгдэхүүний 5 дээж, нийт 57 дээжинд шинжилгээ хийж, 5908 кг маханд гэрчилгээ олголоо.

## **Зургаа. Байгаль орчны чиглэлээр**

“Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор” гол замуудыг камержуулахаар “Ай Ти Эс Θγ” ХХК-тай гэрээ байгуулан ажиллалаа. Баянгол сумын “Цагаан чулуут”-ын орд “Сонортрейд” ХХК-ийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, 2020 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2020 оны байгаль орчны менежмент төлөвлөгөө зэрэг бичиг баримттай танилцаж хянан бүртгэх хуудас олгосон.

### **Долоо.Орон нутгийн өмч, худалдан авах ажиллагааны чиглэлээр**

Аймгийн 2020 оны худалдан авах бараа ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд 19,5 тэрбум төгрөгийн 132 төсөл арга хэмжээ батлагдсанаас 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Орон нутгийн өмчийн газарт захиалагчаас 85 ажлын зураг төсөв, техникийн даалгавар ирүүлсэн, ажлын явц 64,4 хувьтай байна. Үнээс 85 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зарлаж тендер хүлээн авах шатандaa байгаа 37, тендер хүлээн авч үнэлгээг хийж буй 26, гэрээ байгуулах эрх олгогдсон 22 төсөл арга хэмжээ байна.

### **Найм.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

Нийт сумдад цаг үеийн нөхцөл байдал, томуу, томуу төст өвчлөл болон шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын онцгой комисс, шуурхай штабууд гамшгийн эрсдлийн үед ажиллах төлөвлөгөөг тодотгон аймгаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байна. Суманд үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудаар эргүүл шалгалт хийж, дээд шатны байгууллагаас өгсөн захирамж, албан даалгавар болон сумын Засаг даргын шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг цаасан болон цахим хуудас, сумын лед дэлгэцээр, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлах арга хэмжээ авч байна.

Аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, зочид буудал зэрэг байгууллагуудын ариутгал цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт хийх, гар ариутгах нөхцөл бүрдүүлэх, үйлчлэгч болон үйлчлүүлэгчид хувийн ариун цэврийг сахих, амны хаалт зүүж хэвших, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, шаардлага тавих, эцэг эхчүүд бага насны хүүхдийг гадуур дагуулж явах, үйлчлүүлэх, үйлчлэхийг хориглох, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, худалдан борлуулах цагийн хязгаарлалт, нийгмийн хэв журмыг хангах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангахад цагдаагийн байгууллагатай хяналт тавин ажиллаж байна.